

Ноён хутагт Данзанравжаагийн төвөд хэлээр бичсэн “Галбын орны шивдагийн тахил залбирал буман жаргалангийн үүдийг нээгч” зохиолын эх бичиг, туурвил зүйн судалгаа

Хургаагийн СҮГЛЭГМАА*

Монгол Улс, Улаанбаатар,

Монгол Улсын Их Сургууль,

Шинжлэх Ухааны Сургууль,

Утга зохиол, урлаг судлалын тэнхим

Received: Sep 1, 2024

Revised: Oct 7, 2024

Accepted: Oct 26, 2024

Хураангуй: XIX зууны соён гэгээрүүлэгч, Говийн ноён хутагт Данзанравжаагийн төвөд хэлээр бичсэн “Галбын орны шивдагийн тахил залбирал буман жаргалангийн үүдийг нээгч” зохиолын сурвалжийн судалгаа, зохиолын агуулга уран сайхны онцлог, уг зохиолыг бичих болсон түүхэн нөхцөл, хутагт бээр Галбын уулыг тахин шүтэж түүнд олон сайхан дуу шүлэг, тахил залбирлыг зориулж ирсэн шашин соёлын учир холбогдлыг намтар судлалын болон сурвалж бичгийн үүднээс тодруулан үзсэн судалгаа юм.

Түлхүүр үг: Данзанравжаа, Буман жаргалан, Галбын уул, савдаг шивдаг, төвөд хэлт уран зохиол

**Prayer and Worship of the Local Deity of Galba Mountain:
Openingth Gate of Tranquility - A Textological and Compositional
Study of Noyon Khutugtu Danzanravjaa's Tibetan Works**

SUGLEGMAA Hurgaa

Department of Literature and Arts

School of Arts and Science

NUM, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The research of the source of the text “Sacrifice prayer of the Savdag (shivdag) of the Galba territory opens the door to happiness” written in the tibeten language of the 19th century enlightener, poet Danzanravjaa, the content and artistic features of the text, the historical conditions that led to the writing of

* © X.Сүглэгмаа 2024

Email: sugleg99@gmail.com

the text, the nobleman worshiped the Galb mountain. It is a study that clarified the importance of religion and culture, which dedicated many beautiful songs, poems and prayers to him, from the point of view of biographical studies and reports.

Key words: *Danzanravjaa, buman jargalan, mountain Galba, earth god, god mountain, local deity, tibetan literature*

1. Удиртгал

Бурхны шашны нэрт зүтгэлтэн, буддын гүн ухаантан, яруу найрагч, Говийн V ноён хутагт Данзанравжаа Монголын шашин соёл, утга зохиолын амьдралд олон содон бүтээлээ туурвиж онцгой байр суурь эзэлсэн XIX зууны их соён гэгээрүүлэгч билээ. Ноён хутагт Данзанравжаагийн монгол, төвөд хэлээр туурвисан олон зуун бүтээл хэвлэн нийтлэгдэж уншигч олны хүртээл болсоор ирсэн бөгөөд “Үлэмжийн чанар”, “Тунгалаг огторгуй”, “Баян сүмбэр уул”, “Цэвцгэр хурдан шарга”, “Урт сайхан хүрэн”, “Төрж өсгөсөн гөрөөс ээж”, “Тэргэл сарны гэрэл”, “Эрт насны ерөөл”, “Урьхан хонгор”, “Уужимхан зуны гурван сард” “Өвгөн шувуу хоёр” зэрэг дууны бүтээл, “Галбын магтаал”, “Сухавадийн орон”, “Цэцэн ханы үлгэр”, “Суварган өндрийн бараа”, “Бөхөгт айлдсан дуу”, “Галбын хан шиг”, “Баруун зүгийн тэнгэр тулам зэсэн уул” зэрэг уул ус, орон газрын магтаал, “Даш зайсанд хайрласан дуу”, “Дадишура нарт айлдсан дуу”, “Залан Дашцэмбэлд айлдсан шүлэг”, “Шавь Ринчинд сургасан үг”, “Гэвш Шаравт хэлсэн сургаал” зэрэг тодорхой хүмүүсийн дуртгасан ёсоор өгүүлсэн буюу тэдэнд зориулсан шүлэг дуу, “Гурван эрдэнэ”, “Нэгийг хүснэ”, “Хоёр нь”, “Лам гурван эрдэнэ”, “Хиргүй тунгалаг”, “Сэтгэлийг амраагч” зэрэг сургаалын шүлэг, “Саран хөхөөний намтар” гэх мэт олон төрлийн зохиол бүтээлээрээ XIX зууны Монголын уран зохиолд онцгой байр суурь эзэлж ирсэн юм.

Энэ удаагийн судалгаанд миний бие өөрийн хувийн архивд хадгалагдаж буй, Ноён хутагт Данзанравжаагийн төвөд хэлээр зохиосон, “Галбын орны шивдагийн тахил залбирал буман жаргалангийн үүдийг нээгч”¹²⁸ хэмээх нэгэн зохиолын гар бичмэл сурвалжийг танилцуулж энэ зохиолын уран сайхны туурвил зүйн онцлог хийгээд шашин соёлын учир холбогдлын талаас нь тодруулан үзэхийг зорилоо.

2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Энэхүү өгүүлэлд Ноён хутагт Данзанравжаагийн төвөд хэлээр туурвисан “Галбын орны шивдагийн тахил залбирал буман жаргалангийн үүдийг нээгч” нэртэй зан үйлийн зохиолд хамаарах нэгэн бичмэл судрыг судалгааны эргэлтэд оруулж, уг зохиолын уран сайхны хийгээд туурвил зүйн онцлогийг сурвалж бичгийн түвшинд тодруулан танилцуулах юм.

¹²⁸ тө. kalpa'i gzhi bdag gi gsol mchod bde skyid 'bum sgo byed pa zhes bya bzhugs so



3. Судалгааны хэсэг

1. Эхлэл хэсэг
2. Орны эздийг урин залах мөргөлийн хэсэг
3. Тахил өргөх
4. Орны болон орны эздийн магтаал
5. Даатгал, залбирал
6. Төгсгөлийн үг

1. Эхлэл хэсэг. Зохиолд өгүүлэх нь: ༡། |ན་མོ་གུ་རུ། འདིར་ཡུལ་རྩ་གཞི་བདག་གི་བསང་མཚན་ནི། ཐེག་དང་མ་འདྲིས་པའི་བཟའ་བཅས་བརྟེང་བ་བསང་ཇས་དང་བཅས་པ་བཤམས། རྒྱལ་ས་སེམས་སྟོགས་ཐོན་འགྲོ་རྒྱས་ཆར་ནས་བསངས་སྤངས། རྩོད་པའི་ངང་ལས་མཚན་གཏོར་བསངས་ཇས་རྒྱམས། |རང་རང་མིང་ཡིག་དང་པོའི་ཐེག་ལེ་ཡིས། |བརྒྱན་པ་འོད་ལྷ་ཟག་མེད་བདེ་སྤེར་པའི། |རྩ་ཆོགས་མཚན་ཐེན་དངོས་པོ་ཉིད་དུ་གྱུར། | འབྲུག་ལྷ་ས་བརྒྱ་རྩ་ཐུགས་རྒྱ་དུག། |བདེན་སྟོབས་བརྗོད། Намо гүрү. Орны эзний¹³⁰ ариулга тахилд хилэнцтэй холилдоогүй¹³¹ (цагаан идээ, хурам мэдлээс хагацсан мах), ундаа, сан ариулгын эдийг бэлтгэж (вас་སེམས་སྟོགས་ཐོན་འགྲོ་རྒྱས་ཆར་ནས་བསངས་སྤངས།) Итгэл одуулах, бодь сэтгэлийг үүсгэх тэргүүтнийг алин чадлаараа бодоод “Ум базар амирда гүндаали хана хана хум пад, Ум сувава шүдо, сарваа дарма сувава шүдо хам”

¹³¹ Цагаан идээ /гурван хурам мэдлээс хагацсан мах - үхэхийг мэдээгүй хараагүй сонсоогүй ийм мах - худалдааны, өөрөө аяндаа үхсэн амьтны мах/

Тэндээс өмнө зүгийн Сонгинод оршсон

Тэнгэр шивдаг, Их ялгуугсад нугууд

Өөр өөрийн болоод тус тусын хатад ба

Өмөгт хөвгүүн, түшмэл цэргийн ноён цөм... ариусгая”

хэмээн Сонгино хайрхан уулыг тахирын тул түүнийг тойрсон орон газар, хайрхдыг дуудан өгүүлж “тэнгэр шивдаг, их ялгуугсад”-ыг дуудан урьж байгаа нь эхлэлийн хэсэгт өгүүлэгдэж буй. Ер нь Бурханы шашны тахил тайлгын уран зохиолуудад энэхүү газрын эзэн¹³⁵, орны эзэн¹³⁶, орны тэнгэр¹³⁷ гэсэн үг нэршил нийтдээ уул ус, газар орны эзнийг заасан утга боловч хоорондоо утгын зохих ялгаатай болох нь тод харагдана.

Энд өгүүлж буй шивдаг хэмээх ойлголтын тухайд, эрдэмтэн судлаачдын дотроос маш сонирхолтой дүгнэлтийг доктор, профессор С.Дулам багш хийж шивдаг нь “Нага буюу лусын бүлэгт хамаарах бөгөөд олонх тохиолдолд амьтан төрхтэй (зооморф) төсөөлдөг бол савдаг нь тухайн уул усны хүн төрхт (антропоморф) эзнийг хэлж байна уу” (Дулам, 2004: 51) хэмээн өгүүлсэн бол Оросын дорно дахины судлаач К.М. Герасимовагийн “Шарын шашны тогтолцоон дахь Төвөдүүдийн уламжлалт итгэл үнэмшил” (1989) хэмээх угсаатны зүйч, түүхч, дорно дахин судлаачдад зориулсан, дорно дахины угсаатны бүлгүүдийн оюун санааны өвийн онтологи, зан үйлийн судалгааны бүтээлд бидний “шивдаг” хэмээх ойлголтын тухайд уул овоо, гол усны, орон гэрийн, модны, тахирын орны, орон нутгийн, оршуулгын газрын, хот суурин газрын эзэн зэрэг олон үүрэг чиглэлээр хуваагддаг хэмээн өгүүлсэн нь ч бий.

Ноён хутагт энэхүү зохиолын гарчигт “Галбын шивдагийн тахил”¹³⁸ хэмээн тодотгон нэрлэсэн нь учиртай. Ерөөс шивдаг буюу орны эзнийг тахирад зориулсан судар гэдгийг тодотгон ялгаж өгүүлсэн байна. Энэ нь ч цаанаа түүхэн олон учир шалтгаантай биз. Учир нь, ноён хутагт Данзанравжаа хуучин Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу одоогийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Галбын ууланд¹³⁹ олон жил дияан бясалгал номын шидийг гүйцээн сууж 1828-1834 оны хооронд Галбын гурван хийд буюу сүсэгтэн олонд зориулсан Цагаан толгойн хийд, Бурхны шашны улааны урсгалын Эрээтийн хийд, өөрийнх нь бүтээлийн сүм номын орон болж байсан найман шидэт эрдэнийн суварга, Хажидын суварга, Диваажингийн орны Ногоон Авид бурхны суварга, Ловонбадамжунайн гол шүтээн бүхий Дэмчигийн хийд тэргүүтнийг

¹³⁵ тө. sa bdag

¹³⁶ тө. gzhi bdag

¹³⁷ тө. yul lha

¹³⁸ тө. kalpa'i gzhi bdagi gsol mchod

¹³⁹ Галбын уул бол Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг, Монгол Алтайн нурууны төгсгөл үзүүр, баруунаасаа зүүн урагш зүгт сунаж тогтсон 50 гаруй км үргэлжлэх байц хадан цохио, булаг шанд, хайлаасан ам, чулуун хавцлаас бүрдсэн үзэсгэлэнт тогтоц бүхий газрын ховор элемент байгалийн баялгаараа дэлхийд гайхагдсан уулс.

байгуулж, 25 наснаас хойш Галбын уулыг тахиж шүтэн энд төвлөн суусан тухай олон арван түүхэн баримт, аман домог бий. Олны дунд ихэд дэлгэрсэн нэгэн домогт Ноён хутагт 1828 онд Гурван баяны булгийн дэргэд¹⁴⁰ шавь нарынхаа хамтаар “Чү мэг жарз”¹⁴¹ хэмээх рашаан булаг тахих зан үйл хийж байхад нь бүдүүн бор эрээн могой гулгаж ирснийг хараад “Галбын уулын лус намайг залахаар морилж ирлээ дээ” хэмээн бэлгэшээж улмаар уран Чоймбол шавийгаа илгээж Галбын ууланд могойг тавиулаад “Галба орчмын газар орныг сайн ажиглаад дүрслээд ирээрэй” хэмээн илгээсэн, сүүлд өөрөө тэнд хүрч Ханбогд хайрхны дэргэд 7 хоног бясалгал үйлдээд 30 хоног мориор давхиж нутаг орныг сонирхон шинжсэний дараа нутгийн иргэдийг цуглуулан “Энэ нутаг, энэ уул ус хүний сэтгэлд нисваанис буюу муу сэтгэл төрүүлэхгүй, үзсэн сонссон, бодсон санасан нь биеллээ олохын буян хурсан дагшин сайхан орон байна. Энэ газрыг шүтэж чадах юм бол хүний ид шидээс илүү байгалийн ид шид ноёлсон, хүмүүст дэндүү их сайн сайхныг өгч чадах, галав юүлэх, ертөнц мөхөх тэр хэцүү цагт хүн амьтнаа аваад үлдэж чадах нутаг байна. Энэ уул хөрсөн дээрээ эмийн ургамлаар элбэг, хөрсөн доороо эрдэс баялгаар арвин баян сайхан хайрхан юм” хэмээн бишрэн айлджээ гэсэн домог яриа бий. Тэгвэл энэ тухай түүхэн сурвалжид “Тавдугаар ноён гэгээнтний цэдигийн товч хураангуй оршвой”¹⁴²-д

“Тэндээс Эмт бүлээний рашааны газар ирж түр суурьшин ахуйд их л чилээрхэн ном гүрэм ба элдэв зүйлийн арга заслыг үйлдэж таалал барьсан хэмээн алдаршуулан лагшин амгалан болоод баруун Галба уулын зүг залрах замд гэлэн Чоймболыг илгээн Галба уулын газраа ус мод тэргүүтнийг үзүүлсэнд шавь Чоймбол газрын төлөв байдлыг үзээд хэлж ирмэгц Баруун Сөнид вангийн хошууны Да лам Галбын уулыг магтаж “Гайхамшгаар бүтсэн” хэмээх шүлэг дуу гаргаж айлдсаныг зөвшөөрч Галба уулын газрыг нарийвчлан үзэж Хан уулын ойр Чулуун хаалга нэрт газар сууж өдөр хадны дээр хэдэн шавь нартай аруг арухуй саатаж...”

гэх зэргээр өгүүлсэн нь утга агуулгын хувьд зөрүүгүй таарч байна. Хан уулын ойр гэдэг нь байгалийн үзэсгэлэн төгс, Галбын уулан дотроо хамгийн өндөрлөгт орших, сүрлэг асга хадан байц бүхий Ханбогд хайрхныг¹⁴³ өгүүлж байгаа

¹⁴⁰ Мөн Алшаагийн нутагт ч гэж өгүүлдэг.

¹⁴¹ Биеэр өглөг өгөх, нууц тарнийн ухаанд лүйжин тавих эрх авахын тулд зуун найман хүүрийн газар, зуун найман булгийн эх, зуун найман удган модны дэргэд ном уншиж, мууг номхотгож дадлагажихаар бурхны шашны улааны урсгалын зоч ламын олон хоногоор жодгор майхантай явж хийдэг зан үйл.

¹⁴² МҮҮНС, Монгол судлалын фонд, 13316/97 дансны дугаартай хадгалагдаж буй.

¹⁴³ Ханбогд хайрхан нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвөөс 35 км-т, Монгол Алтай нурууны төгсгөл үзүүр Галбын уулсын дунд оршдог ба далайн түвшнээс 1541 м өргөгдсөн, эргэн тойрондоо байгалийн үзэсгэлэнт Алтангэрэлийн дугуй, Хаалгын таг, Үүдэт, Човгын агуй, Чингисийн уургын нүх, Зуун модны ам зэрэг газруудтай. Ханбогд уулыг тойрсон 108 рашаан булаг, 108 цагаан овоо, 108 хадан цохиотой, баруун талаар нь Ундайн гол, зүүн талаар нь

бөгөөд “Чулуун хаалга нэрт газар сууж” гэдэг нь Ханбогд хайрхны урд хормойд өндөр өндөр хад цохион дундуур, урдаасаа хойшоо ордог хавцал жалгын үүдэн дээр, чулуугаар өрж тавьсан мэт том том хадан цохиот газрыг “Чулуун хаалга”, “Хаалган таг” хэмээн нэрлэдэг бөгөөд Ноён хутагт тэр газар буудалласан тухайгаа тод томруун өгүүлжээ.

Ноён гэгээний Галбын ууланд анх очоод буудалласан хэмээн энэхүү товч цадигт гарч буй Чулуун хаалгыг “Шамбалын хаалга” ч гэх бөгөөд энэ тухай нутгийн ардын дунд яригддаг сонирхолтой домог олон бий. “Галба” гэдэг үгийн гарлыг санскрит хэлнээс орчуулан үзэхэд “Шамбалын нийслэл”¹⁴⁴ гэсэн үг юм. Ингээд бодохоор эртний монголчуудын уул усны нэр, байгалийн тогтоц, үүсэл, тэр орон газрын нууцыг үлгэр домогтоо уран сайхан сэтгэлгээ, оюун билгийн ил далд гүн нарийн эрдмээр чандлан нууцалж үлдээсэн баримт сэлт нь үүгээр тарлахгүй. Энэ тухай хожим жич өгүүлэмз.

Энэ бүхний учир Ноён хутагт нэгэнтээ “Энэ орон нутаг бол миний зөвхөн ирээд буцах газар биш, би амьдралынхаа тодорхой хугацааг өнгөрүүлэх ёстой юм байна” хэмээжээ гэх нь ч хожмын олон түүхэн үйл явдал, баримт сэлтээр батлагдан үлдсэн бөгөөд үнэхээр Ноён хутагт Данзанравжаа хэдий өөрийн төрж өссөн өдгөөгийн Дорноговь аймгийн нутаг Өргөн, Эрдэнэ, Хөвсгөл сумын заагт орших Шувуун шанд, Гурван баян, Хамарын хийдийн орон газартаа бурхан шашны ном үйлсээ дэлгэрүүлэн амьдарч байгаад даруй 1828 оноос буюу 25 наснаасаа хойш Галбын ууланд ирж шашин соёл, бүтээл туурвилынхаа нэгэн шүтээн орон болгон сууж Галбын магтаал тэргүүтэн олон зохиол бүтээлээ зориулсан нь ч энэхүү “Галбын орны шивдагийн тахил залбирал буман жаргалангийн үүдийг нээгч” хэмээх зохиолыг бичих түүхэн зүйн олон үндэс шалтгаантайг харуулж байна. Галбын уул бол Монгол Алтайн нурууны төгсгөл үзүүр, баруунаасаа зүүн урагш зүгт сунаж тогтсон 50 гаруй км үргэлжлэх байц хадан цохио, булаг шанд, хайлаасан ам, чулуун хавцлаас бүрдсэн үзэсгэлэнт тогтоц бүхий газрын ховор элемент байгалийн баялгаараа дэлхийд гайхагдсан орон газар бөгөөд Ноён хутагтын зохиосон энэхүү судар нь Галбын орны шивдагийн тахил гэхээр тэр уул орон газрыг бүхэлд нь тахихад өөрөөр хэлбэл дан ганц Ханбогд хайрхан, түүнийг тойрсон хайрхдыг тахихад биш ерөөс

Уртын гол урсаж гардаг байгалийн эрдэс баялаг газрын ховор элементээр баялаг ариун дагшин уул.

¹⁴⁴ Энэ Шамбал хийгээд түүний нийслэлийг Калап гэдэг тухай хамгийн анх эртний Энэтхэгийн Махабхарата болон Пуранд дурдагджээ. Шамбалын орон гэх энэ ойлголт буддын шашинт шавь олны дунд өргөн дэлгэр бөгөөд “оюун санааны орон” буюу хүн энэ насны нэг амьдралаас ангид, сүнсээр, оюун санаагаараа очдог “бурхны орон” юм. Шамбалын орон хаана хэрхэн оршдог талаар дорно дахинд маш олон домог, домгийн өгүүлэмж бий. Мөнх цаст уулаар хүрээлэгдсэн найман талт лянхуа хэлбэрт орон бий, Шамбалын оронд очих зам хоёр байх бөгөөд нэг нь Монголын говьд, нөгөө нь Төвөдийн Кайлас ууланд байдаг гэх мэтээр өгүүлж иржээ.

Галбын уулын орны эзэн буюу шивдагийг тахихад зориулагджээ гэдэг нь эхний энэ хэсгээс тод харагдаж байна.

Мөн дээр өгүүлсэн юлха буюу орны тэнгэрийн тухай ялгамжаатай өгүүлсэн зүйл ч Ноён хутагтын бүтээлд буй. “Тавдугаар ноён гэгээнтний цэдигийн товч хураангуй оршвой”¹⁴⁵ бичмэл эхийн 5-6 дугаар нүүрэнд:

“Тэр газрын орны тэнгэр догшин рид хувилгаан үзүүлж миний шавь нар солиуран өвдөх тэргүүтэн болсонд би бээр Ядам бадма ванчингийн биенд босоод дөл сүрээр дараад андгай тангарагт оруулж номын сахиусан болгох үйлсэд ууланд очирт морины дууг гурван удаа янцгаалган хадан дээр бүжиглэн дэвхэцсэн өлмийн мөр эдүгээ хүртэл бий. Номын сахиусан болгосон Юлха түүний хангал тахилгыг зохиож дүрс байдлыг бүрдүүлж агуйд залж сүлд овоо босгож шашин хувраг даатган сахиулбай. Бас энэ насанд бардах бус амьтны олон явдлыг үзвээс өөрийн сэтгэлд эрэмшихгүй болбоос энэ мэт эцэг богд Дулдуй ажсаагийн айлтгасан ёсоор Маньганбум өөрөөн ба улсаар униуулав”

гэжээ. Энэ юун тухай өгүүлэв гэхээр Хутагт өөрийн Ажааг үгүй болсны хойно, Өвөр хамрын газар хурал номын хийд байгуулахаар Жанжаа эрдэнэ тэргүүтэнд айлтгасанд, Жанжаа гэгээнтэн бээр “Тэр газрын дүрс байдлыг зурж модны тоог тодорхойлон ирмэгц шинжилж хайрласугай” хэмээснийг зарлигчлан бүтээж айлтгасанд тус газрын нэрийг Өвөрбаясгалант хэмээн сольж нэрийдэн сүм барьж болно гэсний дагуу есөн жан хэмжээтэй Ламрим дацан байгуулжээ. Ингээд хийд орноо байгуулсны дараа тэнд сууж байсан шавь нар нь галзуу солио өвчин тусах зэргээр зүй бус үзэгдэл ихэд гарах болсон тул энэхүү юлха буюу орны тэнгэрийг байгуулж Хамарын хийдийн хойхно овоо босгож хангал тахилгыг зохиосон тухай өгүүлжээ. Энд юлха гэдэг төвөд үгийн дуудлагыг шууд хэрэглэн орны тэнгэр босгож тахисан тухайгаа дэлгэрэнгүй өгүүлжээ. Тэгэхээр савдаг, шивдаг, юлха, “газрын эзэн”, “орны эзэн”, “орны тэнгэр” гэдэг монголын бурхны шашинт сүсэгтэн ардын дунд бүгд ялгамжаат дүр байдлыг өгүүлэх бөгөөд савдаг буюу газрын эзэн нь ихэвчлэн тухайн оносон нэг газар нутаг, уул овооны эзнийг, шивдаг гэвэл тодорхой нэг л уул овоог биш түүний ойр орчмын орон газрыг бүхэлд нь эрхшээсэн эзнийг, юлха бол тэр тогтсон нэг орон газрын сахиус тэнгэр гэсэн утгыг тус тус агуулж иржээ.

2. Орны эзнийг урин залах мөргөлийн хэсэг. Зохиолын хоёрдугаар хэсэгт རྩུ་རང་གིས་ཐུགས་ཀའི་འོད་ཟེར་གྱིས། །མཆོག་གསུམ་དཀར་ལྗགས་ལྗེ་བརྒྱད་ཆོགས། །ཁྱད་པར་ཀུན་དེ་རི་ཆུ་དང་། །ཤིང་གི་བདག་པོ་ལྷན་འདུན་ནི། །མདུན་དུ་མཆོག་གསུམ་ལྷན་སྐད་འཇག་ །རིན་ཆེན་རི་བླ་བཅས་པའི་སྤེང་། །མཆོ་རྒྱུད་ས་ནགས་ཆའ་སྐད་ཆོགས་དབུས། །མཆོད་ལྷན་རྒྱ་མཚོ་རྩལ་བཞིན་བཞུགས། ། хэмээн цагаан зүгийн найман

¹⁴⁵ МУҮНС, Монгол судлалын фонд, 13316/97 дансны дугаартай хадгалагдаж буй.

Амарлингуй болон хатуу элдэв үйлээр
Алив цагаан хар сайн муугийн байдлыг барьж
Алин мэт тэнгэр газрын завсар рид хувилгааныг үзүүлэгч хилэнтийн
Аяа найман аймгийн чуулганыг магтъя.

Угаас үргэлжид оршигч, нутгийн хүнийг тэтгэгч
Урд цагаан зүгийн номд үлэмж сүжигтэй
Буяны буман тоот шинжийг дэлгэрүүлэн зохиогч
Орны эзэн савдаг таныг магтъя.

хэмээн шүлэглээд тэрхүү орны эзэн шивдагийг дүрслэн өгүүлэхдээ:

ᠮᠠᠨᠠᠳᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠲᠤᠭ ᠤᠯᠤᠰ
ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ
ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ
ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

*Амандаа өлзий хутгийн дуу эгшгийг аялж,
Ааль эмэгтэй ноёны байдлаар нөхдийн дунд жавхланг үзүүлэн
сэлбэлзсэн*

Ай цагаан тэмээг уналгад унаж,

Алин мэт заримдаа сэнтий дээр суун оршсоныг магтмуу.

ᠮᠠᠨᠠᠳᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠲᠤᠭ ᠤᠯᠤᠰ
ᠮᠠᠨᠠᠳᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠲᠤᠭ ᠤᠯᠤᠰ
ᠮᠠᠨᠠᠳᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠲᠤᠭ ᠤᠯᠤᠰ
ᠮᠠᠨᠠᠳᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠲᠤᠭ ᠤᠯᠤᠰ

Хойд зүгийн шаашин эрдэнийн

Хотол чуулгант байшингийн нэгэн үүдний дэргэд

Хувилгаан лимбийн дуунд дурлагч бүсгүй

*Хүслийн таван эрдмийн баясгалант хуримыг дэлгэрүүлэгч таныг
магтмуу.*

хэмээгээд тэр орны эзэн шивдаг гол эмэгтэйн бие лагшингийн баруун талд нь хөх хар өнгөтэй үхэр толгойт, модны гол, эрдэнийн хайрцаг, ямааны арьс тэргүүтнээр чимэглэснийг, зүүн талд нь суусан дүртэй тэнгэрийн хөвгүүн, ард нь гялбалзах усны эзэн албин, хан ад, тийрэн тэргүүтний олон нөхдийн чуулганаар хүрээлүүлснийг мөн дүрслэн магтжээ. Энд дурдагдан буй Галбын уулын орны эзэн хэмээн дүрслэгдсэн Амандаа өлзий хутгийн дуу эгшгийг аялж, эмэгтэй ноёны байдлаар нөхдийн дунд жавхланг үзүүлэн сэлбэлзсэн, цагаан тэмээг уналгад унаж, заримдаа сэнтий дээр суун оршсон орны эзэн бол эдүгээ нутгийн олны домог аман түүхэнд өгүүлэгдсэн Галбын уулын эзэн лугаа дүр байдал илэрхий тохирч байгаа юм. Аман хуучийн нэгэн домогт мөн Ноён хутагт Галбын уулыг зорьж анх ирээд долоо хоног бясалган сууж 30 хоног уулыг

тойрч хад цохио рашаан булаг жалга бүрийг баруунаас зүүн, дээрээс доор хүртэл шинжээд нутгийн олон түмнийг Алтангэрэлийн дугуйд цуглуулж “Энэ уулын эзэн савдаг бол улаан алчуур зангидсан, баруун гартаа лимбэ барьж үлээсэн, буйлгүй цагаан тэмээ унаж, урд бөхнөөс нь хурганы уут зүүсэн, тэр уутны амнаас аргалын хурганы толгой цухуйсан тийм үзэсгэлэнт бүсгүй эзэнтэй юм. Ээж эзэнтэй учраас гаднаас ирж шүтсэн, мөргөсөн, амьдарсан бүхэнд ээлтэй аж. Би энэ хайрханд зориулж “Гайхамшигт Галба”¹⁵³ буюу “Аврал бадма самбава” гэдэг 10 бадаг магтаал хэлье гээд:

Аврал Бадамсамбава
 Ачит эцэг Хэрүга
 Аяа, миний зүрхэнд
 Ашид цэнгэн соёрх.
 Гайхамшгаар бүтсэн
 Галбын тэр ууланд
 Гадна дотно хоёроосоо
 Гажуу дайсан үгүй л.
 Эелдэг цасан тоорцогтой
 Элдэв цэцгийн цамцтай
 Эрээн зүлгэн хормойтой
 Эрдэм төгс орон бий.
 Сайхан Галбарваас мод нь
 Салаа навч нь найгаад
 Саруул ухаант номчдоо
 Санан даллах байдалтай...

хэмээсэн Энэтхэг, Төвөд, Монголын уран зохиолд эртнээс уламжлан хөгжиж ирсэн орон хийдийн магтаалын сонгодог уламжлалыг хадгалсан, Монголын уран зохиол дахь орон газрын магтаалын сонгодог жишээ болсон “Галбын магтаал” шүлгээ туурвижээ. Энд Ноён хутагт бээр Галбын уулын орны эзэн шивдагийг бүрнээ дүрслэн өгүүлээд түүний чимэг сэлт нь хөх хар өнгөтэй үхэр толгойт модны гол, эрдэнийн хайрцаг, ямааны арьс тэргүүтэн, мөн бараа бологчид нь тэнгэрийн хөвгүүн, ард нь гялбалзах усны эзэн албин, хан ад тийрэн тэргүүтэн тойрсон нөхдийн чуулганыг ч хамт магтан оруулжээ.


5. *Даатгал, залбирал.* Энэхүү зохиолын хамгийн уран яруу үг хэллэг, дүр дүрслэлтэй энэ хэсэгт урьд цагт Чагнаабадмагийн (мутартаа лянхуат - Жанрайсиг)¹⁵⁴ тааллын хувилгаан, нэгэн гэлэн (аяга тахимлаг)-гийн зарлиг

¹⁵³ Эрдэмтэн Д.Цагаан “Галбын магтаал” нэрээр 11 бадаг шүлэг хэвлүүлсэн бий.

¹⁵⁴ Жанрайсиг бурхан нь “Лянхуаг баригч”, “Мэлмийгээр болгоогч” гэсэн ёгт нэртэй бөгөөд хамаг амьтны залбирлыг сонсож, зовлонгоос аврах тангараг тавьсан байдаг тул түүнд зургаан үлэмж чанар байх агаад тэдгээр нь агуу их нигүүлсэл, агуу их хайр, арслангийн зориг зүрх, хорвоог гийгүүлэгч гэрэл, тэнгэр бурхдын манлай, хаа сайгүй орших удвис болно. Эл зургаан

хийгээд үйлсээр шашныг сахиж хуврагийн аймгийг тэтгэсэн тул энэ нутаг оронд оршсон олон төрөлхтөнд хорлол хөнөөлийг тэвчиж, өлзий хутгийг арвижуулж, халдварт өвчин, саад зэтгэрийг амарлиулах; нас буян, хүч дорвиллог, эд баялаг, хийморь, цог заль, язгуур үндэс тэргүүтнийг зуны нуур мэт дэлгэрүүлэн зохиох; ган зуд, аянга мөндөр, үер ус, шуурга, хуй салхи тэргүүтэн сав ертөнцөд хөнөөлт муу шалтгаан бүхнийг цаг хийгээд байдал бүхэнд буцаан зохио; хараал хор хийгээд хар хэл ам, гал мэсний аюул, дайсан дээрэмчин чоно нохой тэргүүтэн шим ертөнцөд хорлогч саад зэтгэр бүхнийг дурдсан төдийгөөр амарлиулан зохио; хурын ус цагтаа бууж, газрын шим дэлгэрээд усны шувууд эргэлдэн үүл манан бүрхэж, огторгуй тэнгэрийн сайн шинжээр хүмүүний байдал амгалантай хотол чуулганд сайн шалтгааныг бүрдүүлэн зохио хэмээн Галбын уулын орон газар амьдарч буй бүхий л төрөлхтний сайн сайхнаар оршин амьдрахын тухайтад гаднаас дайсангүй, дотроос өвчин зовлон хор хөнөөлгүй, сав ертөнцийн муу шалтгаан бүхэн үгүй болж шим ертөнцийн зэтгэр бүхэн дурдсан төдийгөөр арилаад ган зудгүй, огторгуй тэнгэрийн сайн бүхний ивээлээр хүмүүний байдал амгалан дэлгэр байхын бүхий л дурдлыг ёсоор даатган өгүүлжээ. Үүний дараа цагаан балинг өргөөд Манэд ёнсу¹⁵⁵ буруу дутуу хойш өгүүлсний гэм уналыг арилгах уншлага, өлзий хутгийг оршоох Даш уншсанаар тахилын үндсэн хэсэг өндөрлөж байна.

6. Төгсгөлийн үг. Уг зохиол машинд тодорхой өгүүлсэн, зохиолыг хэн, хэрхэн юуны учир зохиосныг энэхүү төгсгөлийн үгэнд дурдаж өгчээ.



Зураг 2. Судрын төгсгөлийн хуудас

Үүнд: “...Бийр үзгийн алтан үсгийг найруулсан буяны хүчээр энэ орны амьтан бүхэн амгалан жаргалангийн гэрлээр туурвиж амьтан бүхэн номт арван явдлыг эдлэх болтугай хэмээсэн үүнийг энэ нутгийн ноёд түшмэл, хар шар нийтээр дуртгасны нигуурт Равжаа нэрт бээр бичив” хэмээн өгүүлжээ.

Уг зохиол хэдийд бичигдсэн он цагийг харин эхлэл төгсгөлийн үгэнд алинд ч тодорхой өгүүлээгүй бөгөөд товч цадиг тэргүүтэнд дурдсан болон


чанар нь там, бирд, адгуус, хүн, асури, тэнгэрийн 6 орны саад тотгорыг арилган сансрын хүрднээс чөлөөлсөн байна.

¹⁵⁵ Дутуу уншсан, буруу тахисан, буруу бодсон алдаа гэмийг арилган зохиох, өлзий оршоох ном.

Цагаан, Д. (1992). *Д.Равжаа. Яруу найргийн цоморлиг*. Улаанбаатар, 83-р тал.
(Tsagaan, D. *D.Ravjaa*. 1992. *Yaruu nairgyn tsomorlig*. Ulaanbaatar.
(Anthology of poetry]

Гадаад хэлээр

Герасимова, К.М. (1989). Традиционное верование тибетцев в культовой системе ламаизма. Нов. [Герасимова К.М. 1989. *Ламаизмын тахилын систем дэх төвөдүүдийн уламжлалт шүтлэг*. Нов.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.